

**ӨВ. БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ,  
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭ  
/2021 оны 4 дүгээр улирал/**

2021.12.15

Өвт


№	Ажлын чиглэл	Үзүүлэлт		Сум, байгууллага /тоон үзүүлэлт/
1	Хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо		13862
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо		420
		Системчлэл хийсэн хууль тогтоомж		
		Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн зүйл, заалтын тоо		13/35
		Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	250
			Байгууллага	8
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	25
Байгууллага	5			
2	Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянах	Хянаж санал өгсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж /гарсан захирамж/		А захирамж 176, Б захирамж 26 нийт 202 шийдвэр гарсан.
		Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж	Хууль зүйн яаманд хянуулж бүртгүүлсэн	-
			Хууль зүйн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан	-
3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлэг		8
		Үүнээс сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо		310
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгаа		40
		Боловсруулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал		29 сэдвээр 6000ш
		Радио, телевизийн нэвтрүүлэг		-
		Сонин хэвлэлээр сурталчилсан		-
		Бусад /		

БАТАЛГААЖУУЛСАН: ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

МЭДЭЭ ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.ДОРЖХАНД



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН  
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ИЛТГЭХ ХУУДАС  
/2021 оны 4 дүгээр улирал/

2021 оны 12 дугаар сарын 15

ӨвТ

Удирдлага зохион байгууллалт болон төрийн захиргааны байгууллагаас  
хэрэгжүүлсэн сургалт, сурталчилгаа

Бат-Өлзий сумын “Эрх зүйн сургалт, сурталчилгааны баг” нь иргэдэд хууль тогтоомж, хуулинд орсон нэмэлт өөрчлөлт, танин мэдэхүйн чиглэлээрх мэдээллийг тухай бүр өгч ажилладаг. Мөн Бүх нийтийн эрх зүйн боловсрол үндэсний хөтөлбөрийн хүрээнд бэлтгэгдсэн эрх зүйн хөтөч нар сумын нэгдсэн групп, Бат-Өлзий сумын урьдчилан сэргийлэх группээр иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх хуулийн сурталчилгааг байнга түгээж, зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.

Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, сургалт, сурталчилгаа хийх, хяналт тавих ажлын хүрээнд Төрийн албаны тухай хуулийн гарын авлагыг төрийн байгууллагуудын албан хаагчдын дундын группээр дамжуулан 225 албан хаагчдад таниулсан. Мөн гарын авлага хэлбэрээр гарган төрийн албан хаагчдад сурталчилсан.



Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор байгууллагууд дотооддоо сургалт зохион байгуулсан. ЗДТГазраас Төрийн албан хаагчид болон багийн Засаг дарга нарт төрийн албаны ёс зүйн талаар сургалт, мэдээллийг өгсөн. Сургалтад нийт 55 албан хаагч хэсэгчлэн хамрагдсан.






2021 оны 10 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд сумын Онцгой комиссын 24 гишүүн гамшгийн бэлэн байдлыг хангах, Команд штабын цахим сургалтад хамрагдсан.



2021 оны 11 дүгээр сарын 14-нд 1, 2, 3, 4, 5, 6 дугаар багуудын малчдын төлөөлөл 60 малчин өрхийг хамруулсан “Малчид, тариаланчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, Малын эрүүл мэндийн тухай хууль, мал эмнэлгийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх зорилго, зорилтуудыг танилцуулан малчдын санал хүсэлтийг хүлээн авч, газрын мэргэжилтнүүдийн бэлтгэсэн 3 төрлийн гарын авлага, мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдийн бэлтгэсэн 4 төрлийн гарын авлага нийт 7 төрлийн гарын авлагыг олшруулан 450 гаруй ширхэгийг тарааж, сумын Засаг даргын ахалсан хөдөөгийн малчидтай уулзалт хийх ажлын хэсэгт өөрсдийн бэлтгэсэн гарын авлагыг 360 гаруй ширхэгийг олшруулан өгч, малчдын гар дээр хүргүүлэн хамтран ажилласан. /Тараасан гарын авлага 880 ширхэг/. Мөн зөвлөгөөнд оролцсон малчид, тариаланчдад Цагдаагийн тасгийн дарга, Татвараас байцаагч нар мэдээлэл өгсөн.



Малчдад тараасан гарын авлага



Малчид тариаланчдын зөвлөгөөний үеэр нутгийн брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн болсон.



2021 оны 11 дүгээр сарын 8-нд ЗДТГазар, Витафит милк ХХК-тай хамтран 18 малчинд сүү бэлтгэх, боловсруулах аргачлал сургалт, хуванцар сав түүний хор нөлөө сургалт зохион байгуулав. Энэ үеэр Витафит милк ХХК-тай гэрээ байгуулж, хамгийн их сүү нийлүүлсэн малчин өрхүүдэд эрүүл, эко цагаан идээ боловсруулах сүүний сав өгч дэмжсэн юм.



Сумын Засаг даргын Тамгын газрын хүсэлтээр 2021 оны 10 дугаар сарын 22, 23-нд Хархорин сум дахь сум дундын шүүх суманд ирж ажиллан иргэдэд хэрэгцээтэй мэдээ, мэдээллийг нотлох баримт бүрдсэн 4 иргэний нэхэмжлэлийг хүлээн авч суманд шүүх хурал зохион байгуулж иргэдийн ажилласан жилийг тогтоосон. 10 иргэний нэхэмжлэлийг хүлээн авсан. Энэ өдрүүдэд Монгол Улсын шүүхийн тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн талаар мэдээлэл өгч, 100 гаруй иргэнд гарын авлага материал тарааж ажилласан.



Түймэрийн аюултай үеүүдэд ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, иргэдэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг цахимаар болон цаасаар хүргэж, сурталчилсан. Сурталчилгаанд 2000 гаруй иргэн хамрагдсан. Мөн хөдөөгийн багийн 250 айл өрхөд ой, тал хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх, асаасан гал, нурам, цогоо бүрэн унтрааж байх санамж бичиг, сэрэмжлүүлэгийг холбогдох мэргэжилтнүүд хийж тараасан.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас Бат-Өлзий сумын зорилтот бүлгийн 38 иргэнд аж ахуй эрхлэлтийн 3 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар төсөл хэрхэн бичих, бизнес эрхлэх анхан шатны мэдээлэлүүдийг өгсөн.




2021 оны 10 дугаар сард Халамжаас-хөдөлмөрт бэлтгэх зорилтын хүрээнд зорилтот бүлгийн 12 иргэнд цахим сургалтыг 2 өдрийн хугацаанд зохион байгуулсан.



ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн “Хүүхдийн хөдөлмөрт үгүй гэж хэлье”, “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт” зөвлөгөө, “Хариуцлагатай аав, ээж” энгийн дүрэм, “Бага насны хүүхдийг ахуйн ослоос урьдчилан сэргийлэх”, “Сүүдэр бүү тусга” аяны зөвлөмж, шторк, “Хүүхдийн ертөнцийг хайрлая хамгаалъя”, “Хүүхэддээ хайраа харуулах бодит арга замууд”, “Хүүхэд бол маш том ертөнц”, “Хүүхдийн хөгжил”, “Амь нэгтэй хөршүүд”, “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай”, “11-15 насны хүүхдэд амьдралыг таниулъя, өөрийнх нь хүчинд итгүүлъя”, хүүхдийг эерэгээр хүмүүжүүлэх 8 арга, “Хүүхдээ дэлгэцийн хамаарлаас сэргийлье” зөвлөмжийг эцэг эхчүүд, иргэдэд цахимаар тогтмол хүргэж ажилласан. Хүүхэд нэг эрдэнэ, хүмүүжил мянган эрдэнэ, Хүүхдийн хөгжлийн онцлог, Хүүхдээ хайрлая, хүүхдийн аюулгүй дүрэм, хүүхэд хүмүүжлийн эерэг арга гарын авлагыг нийт 312 эцэг, эхэд тараасан.

Нийгмийн даатгалын байцаагч өдөр тутамдаа иргэдэд нийгмийн даатгалын аппликейшнийг гар утсанд суулгаж, кодыг нь баталгаажуулан ажиллаж байна. Мөн төрийн албан хаагчдад нийгмийн даатгалын дэвтэр цахимжсантай холбоотой нийгмийн даатгалын аппликейшнийг баталгаажуулан, бүртгэл хөтлөн ажиллаж байна. "Цахим үйлчилгээ-таны сонголт" 21 хоногийн уралдааны дагуу иргэдэд цахим үйлчилгээг сурталчилж, 120 төрийн албан хаагч болон 89 даатгуулагчдад аппликейшн баталгаажуулан, Нийгмийн даатгалын хууль тогтоомжоор сургалт зохион байгуулсан.




2021 оны 10-р сарын 05-нд цэрэгт татагдсан 14 иргэнд нийгмийн даатгалын аппликейшн суулган өгсөн байна.



2021 оны мал тооллогын ажлын хэсэг 12 чиглэлд явж, энэ үеэр Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд өөрсдийн хариуцдаг салбарын хууль, тогтоомж, журам, ажлынхаа чиглэлээр нийт 1000 гаруй ширхэг гарын авлага бэлтгэн малчдад тараасан. Үүнд: Иргэний бүртгэлийн тухай, Нийгмийн халамжийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Хөдөө аж ахуй, Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Ойн тухай хууль, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиуд багтсан.

Боловсрол, соёлын салбарын чиглэлээр зохион байгуулсан сургалт, сурталчилгаа

Соёлын төвөөс “Угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдол” сэдэвт видео сургалтыг бэлтгэн “Бат-Өлзий сумын Угийн бичиг хөтлөлт” цахим хуудсанд байршуулсан. Сургалтыг нийт 2200 хүн үзэж, 10 хүн үзэл бодлоо илэрхийлж коммент хэсэгт сэтгэгдэл бичсэн.



1 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид 1 албан хаагч 5 өрх хариуцан угийн бичиг хөтлүүлж, угийн бичиг хөтлөх заавар зөвлөгөө аргачлалыг тайлбарлан өгч 165 өрхийг хамруулан боршуур тараасан.



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд эцэг, эхчүүдийн дундын группд боловсролын чиглэлээр явуулж буй үйл ажиллагаа болон мэдээ мэдээлэл, цахим сургалт, зөвлөгөө зөвлөмж зэргийг бэлтгэн тогтмол мэдээлсэн. Мэдээлэл сурталчилгаанд давхардсан тоогоор 3000 гаруй иргэн хамрагдсан.

Эрүүл мэндийн салбарын чиглэлээр болон  
Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан эрүүл мэндийн сургалт, мэдээллийг тухай бүр зохион байгуулсан.

ЭМТөвд хэвтэн эмчлүүлсэн нийт 480 иргэнд Коронавирусээс урьдчилан сэргийлэх, болон зохистой хооллолт, идэвхтэй хөдөлгөөн гэх мэт сэдвүүдээр тогтмол мэдээлэл өгч ажилласан.

ЭМДаатгалаар үйлчлүүлэгч 1500 иргэнд эмийн зохистой хэрэглээ сэдвээр мэдээлэл өгч ажилласан.

4 улиралд цахим хуудсанд 42 удаагийн сэрэмжлүүлэг, зөвлөмж, мэдээлэл байршуулсан ба хандалтын тоо 92523. Мэдээллийг сум болон ЭМТ-ийн цахим хуудсаар эмч мэргэжилтнүүд байршуулж байсан. Нийт 1700 ширхэг зөвлөмж хийж, тараасан.

Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг Бат-Өлзий сумын Урьдчилан сэргийлэх цахим сүлжээгээр иргэдэд түгээж ажилласан. Хандалт 2325 хүнд хүрсэн.

2021 оны 4 дүгээр улиралд эрх, зүйн сургалт, сурталчилгааг 48 удаа явуулж, 29 сэдвээр 6000 гаруй зөвлөмж, гарын авлага, тараах материал иргэдэд тарааж ажилласан байна.

БАТАЛГААЖУУЛСАН: ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.ДОРЖХАНД

